



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 01

Улаанбаатар хот

**Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.7 дахь заалт, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 02

Улаанбаатар хот

**Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус
аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 96 дугаар зүйлийн 96.5 дахь хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар баталсугай:
 - 1.1. Нийт хөрөнгийг 41,754,633,913.99 (дөчин нэгэн тэрбум долоон зуун тавин дөрвөн сая зургаан зуун гучин гурван мянга есөн зуун арван гурван) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 31,623,628,781.07 (гучин нэгэн тэрбум зургаан зуун хорин гурван сая зургаан зуун хорин найман мянга долоон зуун наян нэгэн) төгрөгөөр;
 - 1.2. Өр төлбөрийн нийт дүнг 7,241,131,041.61 (долоон тэрбум хоёр зуун дөчин нэгэн сая нэг зуун гучин нэгэн мянга дөчин нэгэн) төгрөгөөр;
 - 1.3. Эзэмшигчийн өмчийг 34,513,502,872.38 (гучин дөрвөн тэрбум таван зуун арван гурван сая таван зуун хоёр мянга найман зуун далан хоёр) төгрөгөөр тус тус баталсугай.
2. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 03

Улаанбаатар хот

**ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх
дүгнэлтийг батлах тухай**

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.14, 96 дугаар зүйлийн 96.4 дэх хэсэг, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7.8.7 дахь заалт, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч баталсугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 04

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6, 7.10, 7.18 дахь заалт, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Г.Эрдэнэбулган, Т.Лхагвасүрэн, Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, Ц.Шинэхүү, М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Норовжамц, Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгосугай.
2. Л.Болормааг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгосугай.
3. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН



**МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ**

2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 05

Улаанбаатар хот

ТУЗ-ийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.13 дахь заалт, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.8.6 дахь заалт, 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

Монголын цахилгаан холбоо ХК-ийн
2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
05 тоот тогтоолын хавсралт



ТУЗ-ийн 2021 оны зардлын төсөв

/Нэгж: төгрөг/

	Зардлын төрөл	Тоо	Нэгж зардал	Давтамж	Нийт дүн
1. Цалин, холбоо, тээврийн зардал					
1	ТУЗ-ийн гишүүний цалин	9	605,000	12	65,340,000
2	ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	1	385,000	12	4,620,000
3	ТУЗ-ийн нарийн бичгийн даргын холбоо, тээврийн зардал	1	40,000	12	480,000
	Цалин, холбоо, тээврийн зардлын дүн				70,440,000
2. Бичиг хэрэг, хурлын зардал					
1	Бичиг хэрэг, хэвлэмэл материал, цай, кофены зардал	1	150,000	12	1,800,000
2	Хурал зохион байгуулах байрны түрээс	1	200,000	4	800,000
3	Хурал зохион байгуулах техникийн бүрэн байдлыг хангах	1	1,900,000	10	19,000,000
4	Бусад зардал	1	110,000	6	660,000
	Бичиг хэрэг, хурлын зардлын дүн				22,260,000
	НИЙТ ДҮН				92,700,000

Тайлбар: Төсөв 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараа (2022) оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хүртэл хугацаанд хамаарна.



МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр

№ 06

Улаанбаатар хот

Охин компани үүсгэн байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1, 12.3 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, 16 дугаар зүйл, Монголын цахилгаан холбоо ХК-ийн дүрмийн 1.6 дахь заалт, 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. Эм Ти Си Сервис оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай охин компанийг /ХХК/-ийг үүсгэн байгуулсугай.
2. Компанийг үүсгэн байгуулахад оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 /нэг сая/ төгрөг бөгөөд нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 /нэг мянга/ ширхэг энгийн хувьцааг гаргахаар тогтоосугай.
3. Эм Ти Си Сервис ХХК нь хугацаагүйгээр дараах үйл ажиллагааг явуулсугай. Үүнд:
 - 3.1. Гадаад, дотоод худалдаа
 - 3.2. Түрээсийн үйл ажиллагаа, менежмент
 - 3.3. Мэдээлэл, технологийн үйл ажиллагаа
 - 3.4. Зуучлалын үйл ажиллагаа
4. Эм Ти Си Сервис ХХК-ийн дүрмийг хавсралтаар баталсугай.
5. Шинээр үүсгэн байгуулсан Эм Ти Си Сервис ХХК-ийн дүрэмд заасны дагуу тус охин компанийн Гүйцэтгэх захирлыг томилж, компани болон дүрмийг зохих журмын дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ч.ПҮРЭВСҮРЭН

Монголын цахилгаан холбоо ХК-ийн
2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
06 тоот тогтоолын Хавсралт.



ЭМ ТИ СИ СЕРВИС ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү дүрэм нь **Эм Ти Си Сервис** хязгаарлагдмал хариуцлагатай компани /цаашид “компани” гэх/-ийн эрх зүйн байдал, үйл ажиллагааны чиглэл, удирдлага, зохион байгуулалт, тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлсон үндсэн баримт бичиг мөн.

1.1. Компанийн оноосон нэр нь **Эм Ти Си Сервис** хязгаарлагдмал хариуцлагатай компани, товчилсон нэр нь **МТС Сервис ХХК** (англиар MTC service limited liability company, товчилсон нэр нь MTC service LLC) болно.

1.2. Компанийн үүсгэн байгуулагч, нийт хувьцааг эзэмшигч нь Монголын цахилгаан холбоо ХК /цаашид “толгой компани” гэх/ байна.

1.3. Компанийн оршин байгаа газар: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 1, МЦХ ХК-ийн 2 дугаар байр, Шуудангийн хайрцаг 1166, Mtcservice@mtcone.net, 70102244

1.4. Компани нь өөрийн бэлгэдэл (лого, туг)-тэй байхаас гадна хууль тогтоомжид заасны дагуу албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

1.5. Бэлгэдлийн загварыг оюуны өмчийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх бөгөөд тэдгээрийг хэрэглэх эрхийг зөвхөн компани эдэлнэ.


Хоёр. Компанийн эрх зүйн байдал

2.1. Компани нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Харилцаа холбооны тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжийн бусад акт, толгой компанийн бодлого, шийдвэр болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

2.2. Компани нь бие даасан тайлан тэнцэлтэй, банкинд харилцах данстай, өөрийн нэрийн өмнөөс эрх эдэлж, үүрэг хүлээдэг, өөрийн тусгаарласан эд хөрөнгөтэй, ашгийн төлөө хуулийн этгээд байна.

2.3. Хувьцаа эзэмшигч нь компанийн хүлээх үүргийг хариуцахгүй бөгөөд Компани нь өөрийн хувьцаа эзэмшигчийн хариуцлагыг хүлээхгүй.

Гурав. Компанийн эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл



3.1. Компани нь ашгийн төлөө үйл ажиллагаа явуулж, хувьцаа эзэмшигчийн хүртэх үр өгөөжийг тогтвортой хангаж, компанийн үнэ цэнийг өсгөхийг эрмэлзэх бөгөөд мэдээллийн технологийн бүх төрлийн үйлчилгээ болон хуулиар хориглоогүй бусад бүхий л ажиллагааг эрхэлнэ.

3.2. Компани нь дараах үйл ажиллагааг эрхлэн явуулна.

3.2.1. Гадаад дотоод худалдаа;

3.2.2. Түрээсийн үйл ажиллагаа, менежмент;

3.2.3. Мэдээллийн технологийн үйл ажиллагаа;

3.2.4. Зуучлалын үйл ажиллагаа.

3.3. Компани нь тусгай зөвшөөрөл шаардагдах үйл ажиллагааг хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн үндсэн дээр эрхлэн явуулна.

3.4. Компани нь үйл ажиллагаагаа хугацаагүй явуулна.

3.5. Компани нь дүрэм, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ болон бусад асуудлаарх өөрчлөлтүүдээ хуульд заасан хугацаанд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

3.6. Компани нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээг эрх бүхий төрийн захиргааны байгууллагаас олгосон өдрөөс эхлэн үйл ажиллагаагаа явуулна.

Дөрөв. Компанийн хувьцаа, хувь нийлүүлсэн хөрөнгө

4.1. Компани нь нэг бүр нь 1,000 (нэг мянга) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 (нэг мянга) ширхэг зарласан энгийн хувьцаатай байна.

№	Хувьцаа эзэмшигчийн нэр	Эзэмших хувьцаа			Хувь нийлүүлсэн эзлэх хувь
		Тоо ширхэг	Нэгж үнэ	Бүгд үнэ	
1.	Монголын цахилгаан холбоо ХК	1,000	1,000	1,000,000	100%

4.2. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь гаргасан энгийн хувьцааны үнийн дүнгийн нийлбэртэй тэнцүү байна.

4.3. Компанийн хувьцаа нь биет бус хэлбэртэй байх бөгөөд компани нь энгийн хувьцааны бүртгэлийг хөтөлж, түүнийг хадгалах ажлыг зохион байгуулна.

4.4. Компанийн энгийн хувьцаа нь толгой компаниас холбогдох шийдвэр гарах хүртэл гагцхүү толгой компанийн мэдэлд байх бөгөөд аливаа хэлбэрээр бусдад арилжаалагдахгүй.



4.5. Компани нь цаашид нэмж хувьцаа болон бусад үнэт цаас гаргах бол тэдгээрийн тоо, гаргах хугацаа, нөхцөлийг хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

4.6. Компанийн хувьцаа нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд компанийн аливаа эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.

Тав. Компанийн удирдлага, түүний эрх хэмжээ

5.1. Компанийн эрх барих дээд байгууллага нь Хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхийг толгой компанийн Төлөөлөн удирдах зөвлөл хэрэгжүүлнэ.

5.2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хэлэлцэж шийдвэрлэнэ.

5.3. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

5.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын товыг зарласнаас хойш зайлшгүй хэлэлцэх асуудал гарсан бол хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож буй саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар хэлэлцэж болно.

5.5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Толгой компанийн Гүйцэтгэх захирал байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаас олгосон бүрэн эрхийн дагуу түүний нэрийн өмнөөс дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.5.1. Компанийн стратегийн зорилго, зорилт, хөрөнгө оруулалтын бодлого, богино, дунд болон урт хугацааны бизнес төлөвлөгөө, төсвийг батлах;

5.5.2. Компанийн гүйцэтгэх захирлыг сонгох, түүнтэй байгуулах гэрээний нөхцөл, түүнд олгох цалин, шагнал урамшуулал, өмч хөрөнгийг захиран зарцуулах эрх, хариуцлагын хэм хэмжээг тогтоож гэрээ байгуулах;

5.5.3. Компанийн зохион байгуулалтын бүтэц, чиг үүрэг, орон тоог батлах.

Зургаа. Компанийн гүйцэтгэх удирдлага, түүний бүрэн эрх, хариуцлага

6.1. Компанийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал хэрэгжүүлнэ.

6.2. Гүйцэтгэх захирал нь Толгой компанийн Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, хэлцэл хийх, гэрээ байгуулах, компанийн эрх ашгийн төлөө түүнийг төлөөлөх зэргээр компанийн нэрийн өмнөөс итгэмжлэлгүйгээр үйл ажиллагаа явуулна.

6.3. Гүйцэтгэх захирлын үйл ажиллагаатай холбогдон үүссэн маргааныг шүүх хянан шийдвэрлэхэд толгой компанийн томилсон итгэмжлэгдсэн төлөөлөгч компанийг төлөөлөн оролцож болно.

6.4. Гүйцэтгэх захирал нь бусад компани, ашгийн төлөө хуулийн этгээдэд албан тушаал хашихыг хориглоно.

Долоо. Салбар төлөөлөгчийн газрын зохицуулалт



7.1 Компани нь өөрийн үйл ажиллагаагаа бие даасан байдлаар болон бусадтай хамтран явуулах зорилгоор салбар төлөөлөгчийн газрыг гадаадад болон аймаг, сум, хот, дүүрэгт ажиллуулж болох бөгөөд салбар төлөөлөгчийн газар байгуулах, хамтын ажиллагааны асуудлыг толгой компанийн гүйцэтгэх захирал шийдвэрлэнэ.

7.2 Салбар, төлөөлөгчийн газар нь компанийн нэрийн өмнөөс түүнийг төлөөлөн компаниас баталсан журмын дагуу үйл ажиллагаагаа явуулах бөгөөд хуулийн этгээдийн эрх эдлэхгүй.

7.3 Гүйцэтгэх захирал нь салбар, төлөөлөгчийн газрын удирдах этгээдийг Толгой компанийн Гүйцэтгэх захирлын бичгээр өгсөн зөвшөөрлийг үндэслэн томилж, чөлөөлөх бөгөөд тэдгээр нь компаниас олгосон итгэмжлэлийн үндсэн дээр үйл ажиллагаагаа явуулна.

Найм. Толгой компанитай харилцах харилцаа

8.1 Компани нь толгой компанитай Компанийн тухай хууль, энэ дүрмийн хүрээнд хамтран ажиллана.

8.2 Толгой компани нь компанийн нийтлэг эрх ашиг, үйл ажиллагаанд хамаарах асуудлыг зохицуулах үүднээс дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

8.2.1 Охин компанийн хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэх болон толгой, охин компани хоорондын харилцааг зохицуулсан аливаа дүрэм, журам, гэрээг батлах;

8.2.2 Компанийн хэвийн үйл ажиллагаа доголдож, санхүүгийн зохистой харьцаа, үзүүлэлт алдагдсан тохиолдолд аудитын дүгнэлтийг үндэслэн үйл ажиллагааг тогтворжуулж, хүндрэлийг даван туулахад чиглэсэн тодорхой төлөвлөгөө, төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

8.2.3 Худалдах, шилжүүлэх үндсэн хөрөнгийн асуудлыг хэлэлцэж, дүгнэлт гаргах;

8.2.4 Их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий гэрээ хэлцлийг хийх эсэх асуудлыг шийдвэрлэх;

8.2.5 Холбогдох мэдээ, мэдээлэл, тайланг гаргуулан авах, тайлан тэнцэлтэй танилцах, шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллагаар шалгуулах;

Ес. Компанийн эрх бүхий албан тушаалтан

9.1. Компанийн Хувьцаа эзэмшигч, Гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий менежер зэрэг Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлд заасан этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно.

9.2. Эрх бүхий албан тушаалтан нь Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.4 дэх хэсэгт заасан үүрэг хүлээж, 85 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээнэ.



Арав. Компанийн хяналтын тогтолцоо

10.1. Компанийн хяналтын тогтолцоо нь дараах бүтэцтэй байна:

10.1.1. Хувьцаа эзэмшигчийн хяналт;

10.1.2. Хөндлөнгийн хяналт.

10.2. Хувьцаа эзэмшигчийн хяналтын чиг үүргийг Толгой компанийн Дотоод аудитын газар хэрэгжүүлнэ.

10.3. Компани нь хөндлөнгийн хяналтын зарчмыг үйл ажиллагаандаа баримтлах бөгөөд санхүүгийн тайланг шалгуулж баталгаажуулан, санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд бүрэн болон хэсэгчилсэн шалгалтыг хөндлөнгийн аудитын компаниар гүйцэтгүүлж болно.

10.4. Хөндлөнгийн аудитын компаниар аудит хийлгэсэн тохиолдолд тайланг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж, шийдвэр гаргана.

Арван нэг. Компанийн санхүүгийн үйл ажиллагаа

11.1 Компани нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, татварын багц хуулийн заалтад нийцүүлэн тогтоосон хугацаанд нь татварын тайлан гаргаж тооцоо хийнэ.

11.2 Компани нь санхүүгийн тайлангаа тусдаа гаргах бөгөөд толгой компани нь нэгдсэн санхүүгийн тайлан гаргана.

11.3 Санхүүгийн тайланд дараах бүрдэл хэсгүүдийг заавал оруулна.

11.3.1 Баланс

11.3.2 Орлого үр дүнгийн тайлан

11.3.3 Мөнгө гүйлгээний тайлан

11.3.4 Хуримтлагдсан ашгийн тайлан

11.4 Компани нь сар бүр санхүүгийн тайлан гаргаж, дараа сарын 10-ны дотор толгой компанид илгээнэ.

11.5 Санхүүгийн тайлангийн үнэн зөвийг гүйцэтгэх захирал хариуцах боловч ерөнхий нягтлан бодогч энэхүү хариуцлагаас чөлөөлөгдөхгүй.

11.6 Санхүү, аж ахуйн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэл, тайлан тэнцэл, татварын тооцоололд хөндлөнгийн байгууллагаар шалгалт хийлгэж, ажил сайжруулах туслалцаа авч болно.

11.7 Хяналт шалгалт, лавлагаа, архивын зорилгоор дараах баримт бичгүүдийг хуульд заасан хугацаагаар хадгална.



- 11.7.1 Компанийн дүрэм түүнд орсон нэмэлт өөрчлөлтүүд
- 11.7.2 Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ
- 11.7.3 Компанийн дотоод бичиг, баримт, материалууд
- 11.7.4 Компанийн салбар болон төлөөлөгчийн газрын дүрэм, гэрээнүүд
- 11.7.5 Нягтлан бодох бүртгэлд тусгагдсан эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийг нотлох баримт бичгүүд
- 11.7.6 Компанийн гүйцэтгэх захирлын тушаал шийдвэр, хурал зөвлөгөөний тэмдэглэл
- 11.7.7 Санхүү аж ахуйн үйл ажиллагааны анхан шатны болон дэлгэрэнгүй бүртгэл, нягтлан бодох бүртгэлийн баримт, бичиг, материалууд
- 11.7.8 Санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан тэнцэл түүнтэй холбогдох баримт, материалууд.

11.8 Компанийн санхүүгийн жил нь тухайн жилийн 1 дүгээр сарын 1-ний өдөр эхэлж 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болно.

Арван хоёр. Компанийг өөрчлөн байгуулах, татан буулгах, төлбөрийг барагдуулах

12.1. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

12.2. Компанийг өөрчлөн байгуулах асуудлыг Компанийн тухай хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

12.3. Компанийг хувьцаа эзэмшигчдийн хурлын болон шүүхийн шийдвэрээр, Иргэний хууль болон Компанийн тухай хуульд заасан үндэслэлээр татан буулгана.

12.4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр татан буулгах комиссыг томилох, татан буулгах хугацаа, журам, зээлдүүлэгчдийн нэхэмжлэлийг барагдуулсны дараа компанид үлдэх эд хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд хуваарилах журам зэргийг тусгасан татан буулгах төслийг хувьцаа эзэмшигчдийн хуралд оруулж, хуралд оролцож байгаа саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор шийдвэрлэнэ.

12.5. Татан буулгах комисс томилсноор тухайн компанийн Хувьцаа эзэмшигчийн болон гүйцэтгэх захирлын бүрэн эрх татан буулгах комисст шилжинэ.

12.6. Татан буулгах комисс нь Компанийн тухай хуулийн 26-29 дүгээр зүйлийн дагуу ажиллаж, улсын бүртгэлээс компанийг хасуулж ажлаа дуусгавар болгоно.

12.7. Татан буулгах комисс үүргээ гүйцэтгэх үедээ өөрийн буруутай үйл ажиллагааны улмаас тухайн компанид ямар нэг хохирол учруулсан бол учирсан хохирлыг хуульд заасан журмын дагуу хариуцна.

12.8. Компанийг улсын бүртгэлээс хассанаар татан буугдсанд тооцно.

Арван гурав. Бусад зүйл

13.1. Энэхүү дүрэмд тусгагдаагүй аливаа асуудал нь Иргэний хууль, Харилцаа холбооны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу зохицуулагдаж, тайлбарлагдана.

13.2. Компанийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, компанитай гэрээгээр ажиллаж байгаа этгээд компанийн нууцад хамаарах мэдээллийг хууль тогтоомжид тусгайлан заасан буюу төрийн эрх бүхий байгууллагаас шаардсанаас бусад тохиолдолд компаниас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр ашиглаж эсхүл задруулахыг хориглоно.

13.3. Компани нь албан хэргийн хөтлөлт болон бичиг баримтыг хадгалах, холбогдох байгууллагад шилжүүлэх ажлыг хууль тогтоомж болон холбогдох дүрэм журамд заасны дагуу зохион байгуулна.

13.4. Энэхүү дүрмийг зөрчиж гаргасан аливаа шийдвэр нь хүчин төгөлдөр бус байна.

13.5. Энэ дүрмийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр хүчин төгөлдөр болно.



---oOo---